

“Хууль, хүний эрх төв” ТББ

Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоо

Мониторингийн тайлан

Улаанбаатар хот

2009 он

Агуулага

Өмнөх үг

Товчхон

Нэг дүгээр бүлэг

1.1 Төслийн багийн танилцуулга

1.2 Мониторингийн хамрах хүрээ, аргачилал

Хоёр дугаар бүлэг :Эрх зүйн орчин

2.1 Шүүхийн тухай хууль

2.2 Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баримталж буй чиглэл

2.3 Эрүүгийн байцаан шийтгэх хууль

2.4 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Гурав дугаар бүлэг: Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох

3.1 Иргэдийн төлөөлөгч гэж хөн бэ.

3.2 Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцохын зорилго

3.3 Иргэдийн төлөөлөгчийн санал шүүхийн шийдвэрт хэрхэн нөлөөлдөг вэ.

3.4 Иргэдийн төлөөлөгчийн эрх үүрэг

3.5 Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохын ач холбогдол

Дөвөр дүгээр бүлэг: Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг сонгох

4.1 Иргэдийн төлөөлөгчийн сонгох шалгуур

4.2 Иргэдийн төлөөлөгч ажиллах хугацаа

4.3 Шүүх хуралдааны бэлтгэл

Тав дугаар бүлэг дүгнэлт зөвлөмж

Өмнөх үг

“Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоо” мониторингийг амжилттай хэрэгжүүлэхэд гүн туслалцаа үзүүлж, мониторинг хийх арга зүйн болоод санхүүгийн дэмжлэг үзүүлэн тусласан Нээлттэй нийгмийн хүрээлэнгийн хамт олонд Хууль хүний эрх төвийн хамт олон гүн талархал илэрхийлж байна. Мөн түүнчлэн бидний ажлыг ойлгон дэмжин, хамтран ажилсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Дээд шүүхийн шүүгчид, Нийслэлийн болон Хан-Уул, Баянзүрх дүүрэг, Төв аймгийн шүүхийн ерөнхий шүүгч, тамгын албаны дарга нар, шүүгчид, иргэдийн төлөөлөгчид болон туршлагаасаа хуваалцсан эрдэмтэн багш нар, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагат оролцож үнэтэй санал бодлоо хуваалцсан өмгөөлөгч, прокуроруудад талархалаа илэрхийлж байна.

Төслийн баг

Товчхон

Монгол улсын Үндсэн хуульд хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэж байх заалтыг нь шударга ёсны шаардлагыг хангах гол шалгуур хэмээн үзэж байна. Гэвч энэ чухал зарчмыг бусад салбар хуулиудад тусгахдаа цөөн тооны хэлбэр төдийхөн заалтуудыг тусгасанаар Үндсэн хуулийн дээрх зарчим жинхэнэ утгаараа хэрэгжих боломжгүй байдалтай байна. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчдийг шүүх хуралдаанд оролцуулж байх зарчмыг хэрэгжүүлэхийн тулд салбар хуулиудад иргэдийн төлөөлөгчдийн ажиллах зарчим, эрх үүрэг, бусад зүйлийг тодруулж өгөөгүй нь хууль боловсруулах үеийн бодлого чиглэл нь ч тодорхойгүй байснаас иргэдийн төлөөлөгч ямар ч үүрэггүй идвэхгүй байдлаар шүүх хуралд оролцож иржээ.

Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгч оролцуулж хамтын зарчмаар ажиллахдаа тэд ямар субъект, тэдний зорилго, ач холбогдол, эрх үүрэг нь юу болох зэрэг бусад зүйлийг салбар хуулиудад тодруулж өгөөгүйгээс иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хэлбэрийн төдий л оролцдог гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл шүүхэд ардчилал хэлбэрийн төдий байна гэсэн үг юм.

Анхан шатны шүүхээс гарч буй шийдвэр, шийтгэх тогтоол Монгол улсын нэрийн өмнөөс гарч байхаар хуульчилсан ч утгаа бол Төрийн нэрийн өмнөөс бүх шийдвэр гардаг гэж үзэж болохоор байна. Учир нь иргэдийн төлөөлөгчийн саналд шүүх бүрэлдэхүүн төдийлөн ач холбогдол өгдөггүй шүүгч дангаар шийдвэр гаргадаг.

Шүүхийн бүх үйл ажиллагаа олон нийтэд ил тод, ойлгомжтой, тэдний санаа бодолд түшиглэсэн байх учиртай ч хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн шүүгдэгч болон зохигчийн¹ гэм буруугийн талаар гаргасан саналыг шүүхийн шийдвэрт хэрхэн тусгах эсэх нь тодорхойгүй бөгөөд огт хуульчлагдаагүй байна.

Эрдэмтэн багш, шүүгч, прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгчид иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохын ач холбогдлын талаар ойлголт туйлын ялгаатай байгаа нь энэ асуудал нилээд бүрхэг хуульчлагдсан нь харагдаж байна.

¹ Иргэийн Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх Тухай хуулийн 26-р зүйл “Нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил, эрх үүрэгтэйгээр оролцож байгаа этгээдийг зохигч гэнэ.”

Шүүхийн хэлэлцүүлэгт оролцох иргэдийн төлөөлөгчдийг сонгох шалгуурыг тодорхойлсон эрхзүйн акт байхгүй тул өмнө нь ардын төлөөлөгчөөр ажиллаж байсан тэтгэвэрийн насны хөгшид, өмгөөлөгч, шүүхийн үйлчлэгч, манаач, жолооч, хуулийн сургуулийн үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутан оролцдог байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс гаргасан удирдамжийн дагуу шүүхэд байнга ажиллах иргэдийн төлөөлөгчийг сонгон ажиллуулж иржээ. Судалгаанд хамрагдсан шүүхүүдэд иргэдийн төлөөлөгчид 2-18 жил тасралтгүй, тогтмол шүүх хуралдаанд оролцож байна.

Ийнхүү иргэдийн төлөөлөгчийг байнгын хүнээр сонгосон, /томилсон/ учир иргэдийн төлөөлөгчид өөрсдийгөө шүүхийн ажилтан хэмээн ойлгож шүүх хуралдаанд өөрсдийн хүсэлтээр оролцох, зарим шүүхийн тамгын хэлтсийн дарга иргэдийн төлөөлөгчдийг сонгон шүүх хуралдаанд оролцуулах үүргээ иргэдийн төлөөлөгчид шилжүүлээд хэвшил болжээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:

1.1 Төслийн багийн танилцуулга

Хууль, хүний эрх” төв нь 2006 онд хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуульчидын санаачлагаар үүсгэн байгуулагдсан нийгэмд үйлчилдэг, ашгийн бус, төрийн бус байгууллага юм. Тус төв нь Монгол улсын хэмжээнд хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргах зорилготой.

Мониторингийн багт Хууль хүний эрх төвийн хуульч, өмгөөлөгч Д.Цэнд-Аюуш, Т.Баяртөгс, хуульч Д.Мөнх-Оргил нар хийж гүйцэтгэв.

1.2 Хамрах хүрээ, хугацаа

Энэхүү зорилтын хүрээнд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоог 4 сарын хугацаанд Нийслэлийн Хан-уул, Баянзүрх, Төв аймгийн шүүхийн тамгын хэлтсийг хамруулан хийлээ

1.3 Аргачилал

Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоог бид зарчмын хувьд ямар ач холбогдолтой байх, бодлого, агуулгын талаас ямар байх болон ямар байгаад ажиглалт, ярилцлага, тандалт, оролцооны болон баримтуудыг үнэлэх зэргээр чанарын судалгаанд тулгуурлан хийлээ.

ХОЁР ДУГААР БҮЛЭГ:

2.1 ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол улсын Үндсэн хуульд хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэж байх заалтыг² шинээр оруулж ирсэн нь шудрага ёсны шаардлагыг хангах гол шалгуур хэмээн үзэж байна. Гэвч энэ чухал зарчмыг бусад салбар хуулиудад тусгахдаа цөөн тооны хэлбэр төдийхөн заалтуудыг тусгасан байна. Тухайлбал хэрэг маргааныг хэлэлцэж шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгч ач холбогдол багатайгаар шүүхийн хэлэлцүүлэгт оролцохоор хуульчилж өгсөн нь Үндсэн хуулийн дээрх зарчим жинхэнэ утгаараа хэрэгжих боломжгүй байдалтай байна.

² Монгол улсын Үндсэн хуулийн 52.2 дүгээр зүйл

Шүүхийн хэлэлцүүлэгт оролцох иргэдийн төлөөлөгчийг сонгох шалгуур, ажиллах зарчим, тэдний эрх үүргийг салбар хуулиудад хэрхэн тусгасан талаар тодруулбал:

2.2 Шүүхийн тухай хууль

Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлд “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ хуульд заасан журмын дагуу иргэдийн төлөөлөгчийг оролцуулна. Иргэдийн төлөөлөгчийг сонгогчдын нэрсийн жагсаалтыг үндэслэн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмын дагуу сонгон авах ажлыг тухайн шүүхийн тамгын хэлтэс зохион байгуулж, шүүх хуралдаанд оролцуулна” хэмээн заажээ.

Шүүгчдийн зөвлөгөөн

Шүүгчдийн зөвлөлгөөнөөс журам гаргах тухай дээрх заалтаар бол Монгол улсад анхан шатны шүүн таслах ажиллагаа явуулж буй сум дундын 30, дүүргийн 9, захиргааны хэргийн 22 шүүх тус бүрдээ шүүгчдийн зөвлөлгөөнөөс нийт 62 журам гарган ажиллахаар ойлгогдож байна. Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийг сонгох шалгуур нь одоогийн дагаж мөрдөж буй хуулиар тухайн орон нутгийн сонгогчдын нэрсийн жагсаалтаас сонгон авах³ заалтаас өөр ямар ч дүрэм, журам байдаггүй байна.

Шүүхийн тухай хуульд шүүгчдийн зөвлөлгөөн хагас жилд буюу 6 сард хуралдаж шийдэхээр⁴ тусгасан байна. Энэ хуулийн заалтаар шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг 6 сар тутамд сонгож байхаар ойлгогдож байгаа ч байнгын иргэдийн төлөөлөгч ажиллаж байна.

2.3 Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс баримталж буй чиглэл

“Шүүхийн тамгын газар, хэлтсийн ажилтны гарын авлага”-д Сонгогчдын нэрсийн жагсаалтаанд бичигдсэн нэрсээс тохиолдлын байдлаар сонгох тухай дурьдсан атлаа шалгуур үзүүлэлтээ зөвхөн хуульч эсвэл эдийн засагч г.м мэргэжлийн хүмүүсийг боловсролын байдал, ажлын дадлага туршлагыг харгалзан нас, хүйс зааж сонгох⁵-оор зааварчлага гаргасан нь тохолдлын байдлаар сонгогдох зарчимтай зөрчилдөж гарсан байна. Гэвч энэ удирдамжийг шүүхийн тамгын төлөөлөгчид баримталдаг байна.

Дээрх гарын авлагад иргэдийн төлөөлөгчийн байнгын тасралтгүй ажиллуулах чиглэл өгсөн байна. “Тамгын хэлтэс ирэдийн төлөөлөгчийг ажиллуулахдаа хэдийгээр төсөвт багтаах шаардлагатай ч **3-4 хүнийг байнгын**, 8 –аас доошгүй хүнийг шаардлагатай үед дуудаж оролцуулахаар тооцсон байвал зохино.”

Мөн удирдамжинд иргэдийн төлөөлөгчийг сонгох шалгуурыг тодорхойлохдоо:

1. Иргэн нь тухайн шүүхэд ойролцоо оршин суудаг, харилцах утас, зан харьцаа, ёс зүй, эрүүл мэндийн шаардлага хангасан, тусгай дунд болон дээд боловсролтой байх,
2. Ял шийтгүүлж байгаагүй зэрэг болно. Гэжээ

2.4 Эрүүгийн байцаан шийтгэх хууль

³ Шүүхийн тухай хуулийн 6.2 дүгээр зүйл

⁴ Шүүхийн тухай хуулийн 68.4.3 дугаар зүйл

⁵ Шүүхийн тамгын газар, хэлтсийн ажилтны гарын авлага 15 дугаар тал

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд дараах 3 заалтаас өөр ямар ч заалт байхгүй, олон шийдвэрлэвэл зохиох асуудал орхигдсон байна.

- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд иргэдийн төлөөлөгч нь оролцогчид асуулт тавих, нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах эрхтэй хэмээн заасан нь гаргасан дүгнэлт саналаа зөвхөн уншиж сонгосон ч болно гэсэн нь уншиж сонгохгүй байсан ч болох ёс төдий зөвхөн хэлбэрийн төдий агуулгыг агуулж байна.
- Шүүхийн анхан шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрдэхэд 3 иргэдийн төлөөлөгчийг оролцуулж байхаар 2007 оны 8 дугаар сарын 9 өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. Энэ заалт нь шүүхээр хянан шийдвэрлэж байсан бүх хэрэгт иргэдийн төлөөлөгч оролцох боломжийг хумиж шүүхийн ардчилалаас ухралт болжээ. Өмнө нь онц хүнд, хүнд гэмт хэрэгт 3, хуульд заасны дагуу шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд 2, бусад хэрэгт 1 иргэдийн төлөөлөгч оролцуулахаар заасан байсан юм.
- Иргэдийн төлөөлөгч гэм буруугийн талаарх санал зөрсөн тохиолдолд саналаа тус тусдаа гаргаж болно гэж заасан ч эсрэг тэсрэг санлыг хэрхэн шийдвэрлэх талаар огт дурьдаж өгөөгүй байна.

Тухайлбал Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тодорхойлогдвол зохих дараах заалт огт тусгагдаагүй байна. Үүнд:

1. Иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд ямар субъект болон оролцож байгааг тодорхойлж өгөөгүйг байна;
2. Шүүгдэгчийн гэм буруугийн талаарх санаалаа уншиж сонгож болно гэсэн нь саналаа уншиж сонгохгүй ч байх боломжийг олгосон туйлын сул заалт болжээ.
3. Шүүх хуралдааны чухам аль үед иргэдийн төлөөлөгчдийн саналыг сонсохыг ч хуульчилж өгөөгүй байна.
4. Иргэдийн төлөөлөгчид шүүгдэгчийн гэм буруугийн талаарх саналаа харилцан ярилцах цаг байхгүй,
5. Шүүхийн хэлэлцүүлэгээс гэм буруугийн тухай 2 өөр санал гарч тусгай санал бичигдсэн үед баримтлах зарчмыг ч тусгаагүй байна.
6. Иргэдийн төлөөлөгчөөр сонгох журам зөрчиж сонгогдсон иргэдийн төлөөлөгч орсон шүүх хуралдаанаас гарсан шүүхийн тогтоолыг эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэж үзэх эсэх талаар огт дурьдаагүй байна.
7. Хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн саналд ач холбогдол өгч шүүхийн шийдвэрт саналыг хэрхэн тусгах эсэх нь тодорхойгүй байна.

2.5 Иргэний Хэрэг Хянан Шийдвэрлэх Тухай Хууль

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад иргэдийн төлөөлөгчдийг шүүх хуралдааны оролцогч хэмээн томъёолж⁶ эрх, үүргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаас нилээд дээгүүр тавьж өгсөн байна. Энэ нь иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд оролцож буй шүүгчийг татгалзах хүсэлт тавих эрхтэй болохыг хуульчилж өгснөөрөө шүүх бүрэлдэхүүнд хөндлөнгийн хяналт тавих боломжийг нээж өгсөн нь сайшаалтай байна.

⁶ Ихшхштхуулийн 85-р зүйл

Гэвч шүүх хуралдаанд оролцохоор томилогдсон иргэдийн төлөөлөгчид хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол зохигч буюу хэргийн нэхэмжлэгч, хариуцагчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно⁷. гэсэн нь иргэдийн төлөөлөгчийг үүргийг сул болгосон заалт болжээ.

ГУРАВ ДУГААР БҮЛЭГ:

3.1 ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОХ НЬ:

Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгч оролцуулж хамтын зарчмаар ажиллахдаа тэд ямар субъект, тэдний зорилго, ач холбогдол, эрх үүрэг нь юу болох зэрэг бусад зүйлийг салбар хуулиудад тодруулж өгөөгүйгээс иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хэлбэрийн төдий л оролцдог гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл шүүхэд ардчилал хэлбэрийн төдий байна гэсэн үг юм.

3.2 Иргэдийн төлөөлөгч гэж хэн бэ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ямар субъект болон оролцож байгааг тодорхойлж өгөөгүй байна. Иргэдийн төлөөлөгч нь шүүх бүрэлдэхүүн, хэргийн оролцогчид, бусад оролцогчдын аль нь ч биш. Тэгвэл иргэдийн төлөөлөгч хэн бэ гэсэн асуулт гарсан ч асуулт хэвээр үлдэж байна.

Иргэдийн төлөөлөгч одоогоор шүүхийн шийдвэрт ямар нэгэн гомдол гаргах эрх бүхий субъект болж чаддаггүй.

Төв аймгийн шүүхийн шүүгчийн ярианаас

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдааны оролцогч хэмээн томъёолжээ.

3.3 Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцох зорилго.

Анхан шатны шүүхээс гарч буй шийдвэр, шийтгэх тогтоол Монгол улсын нэрийн өмнөөс гарч байхаар хуульчилсан ч угтаа бол Төрийн нэрийн өмнөөс бүх шийдвэр гардаг гэж үзэж болохоор байна. Учир нь иргэдийн төлөөлөгчийн саналд шүүх бүрэлдэхүүн төдийлөн ач холбогдол өгдөггүй шүүгч дангаар шийдвэр гаргадаг.

Тэгэхээр иргэдийн төлөөлөгч чухам яах гэж шүүх хуралдаанд оролцдог нь тодорхойгүй зөвхөн шийтгэх тогтоолыг хүчингүй болгохуйн тулд шүүхийн ажиллагаанд туслах төдийхөн л иргэд болон хувирчээ.

Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцуулаагүй бол шүүхийн шийдвэр хууль бус гэж үзэж хүчингүй болох нэг үндэслэл болдог нь бидэнд хүндрэлтэй байдгаас зарим үед ажлаа бодоод жижүүр, жолооч, үйлчлэгч, зарлагаа хүртэл оруулж пармаалдах тохиолдол ч байдгийг нуухгүй хэлье. Тэгэхдээ тэд орон нутгийн сонгуульд оролцдог иргэд шүү дээ.

Шүүгчийн ярианаас

⁷ Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 8 дах хэсэг

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үүргийг бууруулсан нь шүүгчдийг дураараа авирлах, шудрага ёсын индикатор ажиллахаа байх нөхцөл боллоо гэж би ярьдаг.

Эрдэмтэн багшийн ярианаас

Бид иргэдийн төлөөлөгч гэдгээрээ хамгийн гол нь хуулийг зөв хэрэгжүүлж байна уу үгүй юу гэдэг талаасаа хардаг. Нэг талаасаа дүгнэлт гаргах үүрэгтэй. Санал, дүгнэлт гаргах, асуулт асуух эрхтэй гэж хуульчлаад өгчихсөн. Хуулиндаа ч байж байгаа иргэдийн төлөөлөгч шүүхийн бүрэлдхүүнд оролцож байгаа. Энэ нь шүүгч оролцогчдоос иргэдийн төлөөлөгчийг татгалзаж байгаа хүн байна уу үгүй юу гэдгийг асууж байгаагаар илэрдэг шүү дээ.

Иргэдийн төлөөлөгчийн ярианаас

3.4 Иргэдийн төлөөлөгчийн санал шүүхийн шийдвэрт хэрхэн нөлөөлдөг вэ.

1. Шүүхийн бүх үйл ажиллагаа олон нийтэд ил тод, ойлгомжтой, тэдний санаа бодолд түшиглэсэн байх учиртай ч хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн шүүгдэгч болон зохигчий гэм буруугийн талаар гаргасан саналыг шүүхийн шийдвэрт хэрхэн тусгах эсэх нь тодорхойгүй бөгөөд огт хуульчлагдаагүй байна.

Иргэдийн төлөөлөгчдийн гаргаж байгаа санал нь шүүхийн эцсийн шийдвэрт ямар нэг нөлөө үзүүлж чадахгүй байгаа тул тэд шүүх хуралдаанд суух ямар ч ач холбогдолгүй юм. Нөгөө талаар иргэдийн төлөөлөгчийн эрх үүрэг нь ёс төдийн байгаа нөхцөлд тэднийг байлгах шаардлагагүй гэж үздэг.

Өмгөөлөгчийн ярианаас

2. Шүүх хуралдааны чухам аль үед иргэдийн төлөөлөгчдийн саналыг сонсохыг ч хуульчилж өгөөгүй байна.

Одоогийн байдлаар шүүгчид шүүмжлэлийн үе шатны төгсгөлд иргэдийн төлөөлөгчийн саналыг бичгээр авах сонирхолтой ч өмгөөлөгчийн хүсэлтээр саналыг сонсож байна.

3. Иргэдийн төлөөлөгчид зохигчийн болон шүүгдэгчийн гэм буруугийн талаарх саналыг зөвлөлдөх цаг байхгүй.

Судалгаанд хамрагдсан иргэдийн төлөөлөгчөөс та бүхэн зохигчийн болон шүүгдэгчийн гэм буруугийн талаарх саналаа хэдийд зөвлөлддөг вэ гэсэн асуултанд:

- А. “Хурал болохоос өмнө хэрэг уншиж байхдаа хэмээн” нийт оролцогчдын 20 хувь нь,
- Б. “Санал төдийлөн зөрдөггүй” хэмээн 80 хувь нь хариулж байлаа.

Иргэдийн төлөөлөгчдийн нэг гишүүн нь саналаа бичгээр үйлдэж түүнийгээ шүүх хуралдааны явцад дамжуулан уншиж гарын үсэг зурдаг байна. Тэд хороондоо ярилцах нь шүүх хуралдааны дэгийг зөрчих бололтой

Судалгааны багийн ажилтны тэмдэглэлээс

Иргэдийн төлөөлөгч нөгөө төлөөлөгчөөс “Энэ хэрэг чинь хангалттай шалгагдсан юм байгаа биздээ. Гэм буруутай юу” хэмээн асуухад “Хангалттай, буруутай” хэмээн хариулахад за за гээд гэм буруутай гэсэн саналд гарын үзэг зурж байлаа.

Ажиглалтын багийн тэмдэглэлээс

4. Шүүхийн хэлэлцүүлэгийн явцад иргэдийн төлөөлөгч гэм буруугийн тухай 2 өөр санал гарч тусгай санал бичигдсэн үед баримтлах зарчим аль ч процессийн хуульд тусгаагүй байна.

Судлагаанд хамрагдсан шүүхүүд дээр тусгай санал бичигдэж байсан тохиолдол сүүлийн нэг жилийн дотор гараагүй байна.

3.5 Иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад иргэдийн төлөөлөгчийн үүргийг эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаас нилээн дээгүүр үүрэгтэй байхаар хуульчилж өгсөн байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд иргэдийн төлөөлөгчдийн эрх үүргийг ёс төдий цөөн эрхийг тусгаад үүргийг огт тусгаагүй нь иргэдийн төлөөлөгч эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд ямар үүрэг хүлээж оролцох нь тодорхойгүй болсон байна. Мөн хуульд ...иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж заавал шүүхэд бичгээр мэдэгдэх бөгөөд ...иргэдийн төлөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно⁸ гэсэн заалтаас харахад иргэдийн төлөөлөгч Үндсэн хуульд заасан заалтын дагуу шүүх хуралдаанд заавал оролцох онцгой субъект мөн юм. Гэтэл энэ заавал оролцох субъектийн эрх хэмжээ, хүлээх үүрэг нь хууль бүр дээр өөрөөр заагдсан нь анхаарал татав.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	
Эрх:	Үүрэг:
<ul style="list-style-type: none"> - Иргэдийн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэхэд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, - Шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах, - Нотлох баримтыг шинжлэхэд оролцох, 	<ul style="list-style-type: none"> - Шүүгчдийн зөвлөлгөөнөөс хууваарилсан шүүх хуралдааныг таслахгүй байх, - Өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлын нууцыг задруулахгүй байх, - Шүүх хуралданы дэгийг сахин

⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 242.1 дүгээр зүйл

зохигч гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих, - Хэргийн үйл баримт зохигчийн гэм буруугийн талаар бичгээр дүгнэлт гаргах ⁹	биелүүлэх, - Хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар гаргасан дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгох
--	--

<i>Эрүүгийн байцаан шийтгэх хууль</i>	
Эрх:	Үүрэг:
Шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих, Нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах ¹⁰	Байхгүй

<i>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль</i>	
Эрх:	Үүрэг:
Хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хий, Нотлох баримт шинжлэхэд оролцох, Нэхэмжлэгч, хариуцагч тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, гэрч, шинжээчид асуулт тавих, Нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах ¹¹	<ul style="list-style-type: none"> - Хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн дүгнэлт гаргах, - Өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх - Шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх

3.6 Иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралдаанд оролцохын ач холбогдол

Судалгаанд хамрагдсан шүүгч, прокурор, өмгөөлөгчид иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд идвэхигүй оролцдог, хуулинд заасан учраас л оролцож байгаа, билэг тэмдгийн чанартай, ач холбогдолгүй гэсэн дүгнэлтүүдийг өгсөн нь тэднийг сонгон шалгаруулж аваагүйтэй холбоотой гэж дүгнэж байна.

Эрдэмтэн багш, шүүгч, прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгчид иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцохын ач холбогдлын талаар ойлголт туйлын ялгаатай байгаа нь энэ асуудал нилээд бүрхэг хуульчлагдсан нь харагдаж байна.

3.6.1 Байцаан шийтгэх ажиллагаанд оролцдог хуульчид иргэдийн төлөөлөгчийн талаарх үзэл хандлага

Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцож байгаа нь тийм ч тодорхойгүй хууль зөрчихгүй шийдвэр хүчинтэй байх гэж л хуралдаанд оролцдог. Тэднийг хаанаас хэн сонгон шалгаж байгаа нь тодорхойгүй өндөр настай хэдэн хөгшид л байдаг. Шийдвэрт нөлөөлөх санал гаргадаггүй ихэвчлэн

⁹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86.2 дугаар зүйл

¹⁰ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 34.1 дүгээр зүйл

¹¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйл

прокурорын үүргийг л гүйцэтгэдэг. Ийм байдлаар байвал иргэдийн төлөөлөгчийн хэрэг огт байхгүй. Улсын төсөвөөс хумсалдаг хүмүүсийн тоог л нэмэгдүүлж байгаа хэрэг гэж үзжээ.

3.6.2 Эрдэмтэн судлаачдын иргэдийн төлөөлөгчийн талаарх үзэл хандлага

Шудрага ёсны шаардлагыг хангах гэж хуулийн зүйл заалт мэддэг биш хууль мэддэггүй энгийн иргэдийн ердийн ухамсраар шудрага ёсны шаардлагыг үндэс болгож шийдвэр гаргахыг чухалчилдаг. Хуульчийн толгойд хуулийн зүйл заалт л байгаад байдаг. Хамгийн түрүүнд шүүгчийн толгой, нүд 2-т хуулийн заалт орж ирдэг. Иргэдийн төлөөлөгч хууль мэдэх албагүй. Тэр хүн зөвхөн шудрага ёсны үүднээс хандах ёстой. Тийм учраас эрх зүйн тогтолцоотой улс орнуудад иргэдийн төлөөлөгчдийг оролцуулж байгаа явдал нь хууль ёс, шудрага ёс 2-г хослуулах үүднээс оруулдаг.

Иргэдийн төлөөлөгч гэм буруутай эсэх асуудлыг хөндлөнгийн нөлөөнд орохгүйгээр төв голч байр суурьнаас харж хэлэх хүнийг олж сонгох нь хамгийн чухал асуудал. Түүнийг яаж ажлаас нь чөлөөлөх, ямар урамшуулал олгох зэрэг нь зохион байгуулалтын асуудал ба түүнийг шийдэж болох маш хямдхан асуудал. Харин тийм сайн хүнээ яаж шалгаруулах вэ гэдэг л байна. Тодорхой хугацаагаар сонгох хэрэгтэй. Богинохон хугацаагаар сонгоод байх хэрэгтэй. Иргэдийн төлөөлөгчдийн дуу хоолой өндөр болоод ирвэл нөлөөтэй болчихлоо гээд түүн дээр ажиллах гээд байх болчихно. Тийм учраас хурдан хурдан солигдож байдаг байх хэрэгтэй.

ДӨРӨВ ДҮГЭЭР БҮЛЭГ: ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОХ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ

4.1 Иргэдийн төлөөлөгчийг сонгох шалгуур

Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг хэрхэн, яаж, ямар хугацаагаар сонгох шалгуурыг тодорхойлсон эрхийн акт байхгүй байна. Мониторингинд хамрагдсан нийслэлийн 2 дүүргийн болон орон нутгийн нэг шүүхэд шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийг сонгох тухай журам байгаагүй нь Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйл 2 дах хэсгийн хэрэгжилт бэлэгдлийн чанартай заалт байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

Шүүхийн тамгын газар хэлтсийн ажилтны гарын авлагад шүүгчдийн зөвлөлгөөнөөс “Иргэдийн төлөөлөгчийг сонгогчдын нэрсийн жагсаалтаас сонгон авах” журмыг тогтоохдоо тухайн шүүхийн харъяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, онцлог байдал, хүн амын болон байгууллагын нягтрал, хэрэг маргааны гаралтын түвшинг харгалзан сонгогчдын нэрсийн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг хэрхэн сонгох талаар тодорхойлсон байна. Тухайлбал:

- Сонгогчдын нэрсийн жагсаалтад бичигдсэн нэрсээс тохиолдлын байдлаар сонгох
- Баг, хороо тус бүрээс тодорхой тооны хүмүүс сонгох
- Зөвхөн хуульч эсвэл эдийн засагч г.м мэргэжлийн хүмүүсийг сонгох
- Боловсролын байдлыг харгалзан сонгох
- Ажлын дадлага туршлагыг харгалзан сонгох
- Нас, хүйс зааж сонгох гэх мэт гэжээ.

Сонгогчдын нэрсийн жагсаалтад тухайн иргэний овог, нэр, нас, хүйс, регистрийн болон иргэний үнэмлэхний дугаар, гэрийн хаягнаас өөр мэдээлэл байдаггүй. Тэгэхээр дээр заасан мэргэжил, боловсрол, ажлын дадлага туршлагыг хэрхэн тодорхойлж сонгох нь ойлгомжгүй байна. Асуулганд

хамрагдсан 8 иргэдийн төлөөлөгчдийн 3 нь хуулийн мэргэжилтэй, 1 нь ня-бо, бусад нь ногоочин, тогооч, хөдөө аж ахуйн гэх мэт мэргэжлийн хүмүүс байв.

Шүүхийн хэлэлцүүлэгт оролцох иргэдийн төлөөлөгчдийг сонгох шалгуурыг тодорхойлсон эрхзүйн акт байхгүй тул өмнө нь ардын төлөөлөгчөөр ажиллаж байсан тэтгэвэрийн насны хөгшид, өмгөөлөгч, шүүхийн үйлчлэгч, манаач, жолооч, хуулийн сургуулийн үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутан оролцдог байна. Тухайлбал:

Хан-Уул дүүргийн шүүх иргэдийн төлөөлөгчөөр өмгөөлөгч Ө.Пүрэвийг, Баянзүрх дүүргийн шүүх Хилийн цэргийн дээд сургуулийн үйлдвэрийн дадлага хийж буй хуулийн ангийн оюутныг шүүх хуралдаанд оролцуулж байлаа.

4.2 Иргэдийн төлөөлөгч ажиллах хугацаа

Иргэдийн төлөөлөгчдийг ямар хугацаагаар сонгодог талаар хуульд ямар нэгэн заалт байхгүй байна. Тэгэхээр одоо ажиллаж байгаа иргэдийн төлөөлөгч өөрөө хүсэлтээрээ татгалзах хүртэл ажиллаж болно гэсэн ойлголтыг төрүүлж байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс гаргасан удирдамжийн дагуу шүүхэд байнга ажиллах иргэдийн төлөөлөгчийг сонгон ажиллуулж иржээ. Судалгаанд хамрагдсан шүүхүүдэд иргэдийн төлөөлөгчид 2-18 жил тасралтгүй, тогтмол шүүх хуралдаанд оролцож байна. Тэд өөрсдийн орон нутгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор сонгогдсон, Шүүхийн тамгын газрын даргын тушаалаар томилогдсон хэмээн ойлгож өөрсдийгөө шүүхийн ажилтан гэж ойлгодог ажээ.

Би 1990-ээд оноос иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон одоог хүртэл 18 жил ажиллаж байна. Анх биднийг Зуунмод сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлаас сонгодог байсан. Сүүлд 2000 оноос аймгийн шүүхийн тамгын хэлтсийн даргын томилолтоор явж байгаа. Хуулиараа тийм болсон юм байна лээ.

Иргэдийн төлөөлөгчийн ярианаас

4.3 Шүүх хуралдааны бэлтгэл

Шүүхийн тухай хуульд шүүхийн тамгын хэлтсийн дарга шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг тухайн орон нутгийн сонгогчдын нэрсийн жагсаалтаас сонгож шүүх хуралдааны бэлтгэлийг хангах үүрэгтэй¹² байхаар заасны дагуу тамгын хэлтсийн дарга нар энэхүү үүргээ 2-18 жилийн өмнө хийж гүйцэтгэсэн тул одоо шүүхийн тамгын дарга, төлөөлөгчид иргэдийн төлөөлөгчид урамшуулал өгөх төдийхөнөөр үүргээ гүйцэтгэж байна.

Ийнхүү иргэдийн төлөөлөгчийг байнгын хүнээр сонгосон, /томилсон/ учир иргэдийн төлөөлөгчид өөрсдийгөө шүүхийн ажилтан хэмээн ойлгож шүүх хуралдаанд өөрсдийн хүсэлтээр оролцох, зарим шүүхийн тамгын хэлтсийн дарга иргэдийн төлөөлөгчдийг сонгон шүүх хуралдаанд оролцуулах үүргээ иргэдийн төлөөлөгчид шилжүүлээд хэвшил болжээ.

Төв аймгийн шүүх иргэдийн төлөөлөгч дундаас ахлагч томилан ажиллуулдаг байна. Ахлагч долоо хоногт болох шүүх хуралдааны товын дагуу шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн хуваарыг гаргаж иргэдийн төлөөлөгч нарт мэдэгддэг байна. Мөн Хан-Уул, Баянзүрх

¹² Шүүхийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 5.1 дэх хэсэг

дүүргийн шүүхийн иргэдийн төлөөлөгчид өөрсдөө ирэх долоо хоногт болох хуралдааны товыг мэдэж өөрсдөө хуралд оролцохоор ирдэг байна.

Би иргэдийн төлөөлөгчөөр 6 жил ажиллаж байна. Манай тамгын дарга намайг иргэдийн төлөөлөгчийн ахлагчаар томилсон. Миний үүрэг бол шүүх хурлын товын дагуу иргэдийн төлөөлөгч нараа хуралдаанд оролцох хуваарыг гаргах юм. Мөн өөрөө ч шүүх хуралдаанд оролцдог.

Төв аймгийн иргэдийн төлөөлөгчийн ярианаас

Бид дараа долоо хоногт болох шүүх хуралдааны зарыг Баасан гаригт өөрсдөө мэдэх үүрэгтэй. Тэгээд л хуралдаан болохоос өмнө ирдэг. Түүнээс биш тамгын төлөөлөгч бидэнд хурлын зар түгээдэггүй.

ХУД-ийн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн ярианаас

Анхан шатны шүүхэд тухайн орон нутгийн сонгогчдын нэрсийн жагсаалт огт байдаггүй, тухайн орон нутгийн хурал, засаг даргын тамгын газарт байдаг бөгөөд шүүх түүнийг авч хэрэглэдэг туршлага алга.

Сонгогчдын нэрсийн жагсаалтад тухайн иргэний овог, нэр, нас, хүйс, регистрийн болон иргэний үнэмлэхний дугаар, гэрийн хаягнаас өөр мэдээлэл байдаггүй. Тэгэхээр дээр заасан мэргэжил, боловсрол, ажлын дадлага туршлагыг хэрхэн тодорхойлж сонгох нь ойлгомжгүй байна. Асуулганд хамрагдсан 8 иргэдийн төлөөлөгчдийн 3 нь хуулийн мэргэжилтэй, 1 нь ня-бо, бусад нь ногоочин, тогооч, хөдөө аж ахуйн гэх мэт мэргэжлийн хүмүүс байв.

Би иргэдийн төлөөлөгчийг сонгох талаар дүрэм журам байдгыг мэдэхгүй. Надад сонгогчдын нэрсийн жагсаалт огт байхгүй, би мэдэхгүй. Хэрэв байдаг бол дарга дээр л байгаа байх.

Тамгын төлөөлөгчийн ярианаас

Үүгээр ч зогсохгүй тухайн орон нутагт амьдардаггүй иргэн шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр байнга шүүх хуралдаанд оролцдог байна. Аймгийн хэмжээнд байнга ажиллахаар сонгогдсон иргэдийн төлөөлөгч аймагт байгаа бүх сум дундын шүүхийн хуралдаанд оролцож байна. Өөрөөр хэлбэл аймгуудын сум дундын шүүхүүд нь сумдыг нутаг дэвсгэрийн байдлаар нь хувиарлан авч аймаг тус бүрт 2-3 сумын шүүх ажилдаг учир нэг сумын иргэд л шүүхийн хэлэлцүүлэгт оролцож байгаа ажээ. Мөн Судалгааны явцад СХД, ЧД-ийн нутагт амьдардаг иргэд СБД-гийн шүүхэд иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцдог мэдээлэл ирсэн ч бидний мониторингийн хүрээнд хамрагдаагүй учир нарийвчлан судлаагүй.

Шүүх хуралдаанд оролцдог иргэдийн төлөөлөгчийн ажиллах журам байдаг эсэх талаар мэдэхгүй байна. СХД-ийн иргэн СХД-гийн шүүхэд иргэд төлөөлөгчөөр ажиллаж байгаад хүүхэд нь өмгөөлөгч болсон тул СБД-гийн шүүхэд иргэдийн төлөөлөгчөөр ажиллаж байна. Энэ мэт олон зүйл иргэдийн төлөөлөгч хийж буй иргэдээс гардаг.

Өмгөөлөгчийн яриалцлагаас

ТАВ: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Одоогийн манай улсад үйлчилж байгаа хуулиар шүүх хуралд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчдийн зорилго, ач холбогдол тодорхой бус, гүйцэтгэх үүрэг нь бага, хэлбэрийн төдий байна. Тэдний гаргасан санал нь шүүхийн шийдвэрт тусгалаа олдоггүй ач холбогдолгүй учир иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулах зарчмын асуудалд илүү анхаарч Шүүхийн тухай, Эрүү, Иргэн, Захиргааны процессийн хуульд нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах шаардлага урган гарч байгааг сануулан

Монгол улсын Ерөнхийлөгч, Хууль тогтоогчид, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга нарт Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн зорилго, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор шүүх хуралдаан явуулахдаа удирдлага болгодог процессийн хуулиудад дараах заалтыг тусгахын зөвлөж байна. Үүнд:

8. Иргэдийн төлөөлөгчид эрүүгийн хэргийг шүүн хэлэлцэх хуралдаанд ямар субъект болон оролцож байгааг тодорхойлох,
9. Шүүгдэгчийн гэм буруугийн талаарх санаалаа уншиж сонсгож болно гэсэн нь саналаа уншиж сонсгохгүй ч байх боломжийг буюу эрх олгосон заалтыг үүрэгтэй болгон өөрчлөх,
10. Шүүх хуралдааны чухам аль үед иргэдийн төлөөлөгчдийн саналыг сонсох,
11. Иргэдийн төлөөлөгчид шүүгдэгч, зохигчдийн гэм буруугийн талаарх саналаа харилцан зөвлөлдөх цагтай байх,
12. Шүүхийн хэлэлцүүлэгээс гэм буруугийн тухай 2 өөр санал гарч тусгай санал бичигдсэн үед баримтлах зарчмыг ч тусгах, эсвэл зөвхөн нэг шийдэлд хүрсэн байх,
13. Иргэдийн төлөөлөгчөөр сонгох журам зөрчиж иргэдийн төлөөлөгчөөр орсон шүүх хуралдаанаас гарсан шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр ЭБШХ, ИХШХШ тухай хуулиудыг ноцтой зөрчсөн гэж үзэх эсэх,
14. Хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн саналд ач холбогдол өгч шүүхийн шийдвэрт саналыг хэрхэн тусгах эсэхийг тус тус хуульчлахыг,

Шүүхийн тухай хуульд иргэдийн төлөөлөгчдийн сонгох шалгуур, тэдний ажиллах хугацаа зэрэг чухал зүйлсийг нарийвчлан тусгахыг зөвлөж байна.

1. Орон нутгийн сонгогчдын нэрсээс тохиолдлын байдлаар иргэдийн төлөөлөгчийг сонгох заалтыг хэвээр нь үлдээх бөгөөд харин иргэдийн төлөөлөгчийн үүрэг, шудрага ажиллах талаарх заалтыг нарийвчлах
2. Сонгогдсон хүмүүсийг шүүгчид батламжилж байгааг өөрчлөх,
3. Бүх насаар нь иргэдийн төлөөлөгчөөр сонгож байгаа практикийг өөрчлөн богино хугацаагаар ажиллуулахаар,

4. Сум дундын шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг тухайн сумын сонгогчдын нэрсийн жагсаалтаас тохиолдлоор сонгон авч байх зэрэг олон асуудлыг тусгасан заалтуудыг баталгаажуулахыг зөвлөж байна.